# БНМАУ
# БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН УЛСЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

1992 оны 06 сарын 16 А/82

Улаанбаатар хот

Ахмадын хороо байгуулах тухай

"Тэтгэврийн насны ахмадуудад тавих анхаарал халамжийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1991 оны 188 дугаар тогтоол, Монголын ард түмний ахмад үеийн талаар баримтлах, төрийн бодлогын тухай Монгол улсын Ерөнхийлөгчийн 1992 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 15 дугаар зарлиг, төрийн бодлогыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол улсын Засгийн газрын 1992 оны 3 дугаар сарын 13-ны 45 дугаар тогтоолын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Хорооны дэргэдэх Ахмадын хороог дор дурдсан бүрэлдэхүүнээр байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ахмадын хорооны даргаар: | С.Банзрагч | -хорооны дэд дарга |
| Нарийн бичгийн даргаар: | Ц.Пилдэндулам | -ерөнхий хэлтсийн мэргэжилтэн |
| Гишүүдэд: | Д.Дамбадорж | - санхүү хангамжийн хэлтсийн дарга |
| | Н.Цэнджав | - өндөр настан |
| | Н.Цэнд | - өндөр настан |

2. Ахмадын хороо /н.Банзрагч/-нд даалгах нь:

а/Тэтгэврийн насны ахмадуудад тавих анхаарал халамжийг нэмэгдүүлэх талаар гарсан төр засгийн шийдвэрийг биелүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

б/төв аппаратад ажиллаж байгаад насны тэтгэвэрт гарсан ахмад хүмүүсийн бүртгэл судалгааг шинэчилж амьдрал ахуйд нь туслах ажлыг зохион байгуулах;

в/ахмадын хорооноос зохиосон ажлыг тэргүүлэгчдийн хуралд жил бүр танилцуулж байх.

3. Тус тусынхаа байгууллагын дэргэд ажиллаж байгаа ахмадын хэсгийн ажилд бодит туслалцаа дэмжлэг үзүүлэн, тэтгэвэрт гарсан ахмадуудын бүртгэл судалгааг шинэчлэн, тэдний төлөө боломжтой бүх талын арга хэмжээ авч, зохиосон ажлынхаа товч тайланг хорооны Ерөнхий хэлтэст жил бүрийн 12 дугаар сарын 1-нд ирүүлж байхыг хорооны харьяа байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан БОХЯ-ны сайдын 1988 оны 119 тоот тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГА З.БАТЖАРГАЛ